

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 17

1.	<i>Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	8 – 11
2.	<i>Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал</i>	11 – 13
3.	<i>Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	13 – 14
4.	<i>Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	15 – 17

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Т.Доржханд;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ө.Шижир, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Баярсайхан нар байлцав.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үг хэлэв.

Төрийн байгуулалтын байнгын хороо Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын нэрийг дэвшүүлснийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг танилцуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Л.Мөнхбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүнээс 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүнээс 2025 оны 06 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 08 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийг танилцуулъя.

Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна.

Ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 06 сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Эцсийн хэлэлцүүлэг.

Хоёр.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслийг хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Дөрөв.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүнээс 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалд орёё.

**Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хууль, тогтоолын төслүүд**
/Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр
өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.1-д хуулийн тайлбарыг танилцуулъя.

42.1-д хуулийн төслийг холбогдох Байнгын хороо дараах журмаар нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

42.1.1.нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх.

42.1.2.энэ хуулийн 42.1.1-д заасан төсөл болон танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр хуралдаанаар хэлэлцэнэ.

Ингээд төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлгийг бэлдэх тухай танилцуулгыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монгол улсын Ерөнхий сайдаас 2025 оны 06 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулахад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу нэг өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан тул анхны хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэг явуулж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 06 сарын 25-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанд төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Б.Баярбаатар гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, С.Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Д.Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Б.Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын референт, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга.

Б.Баярбаатар даргын микрофоныг нээе.

Б.Баярбаатар: Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулийг дэмжиж байгаа.

Тэгээд яаралтай хэлэлцэж батлаад ажилд нь оруулах нь зөв байх гэж бодож байна.

Сая зүгээр би нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс, манай Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг, Д.Бум-Очир, миний бие байлаа.

Ингээд бас нэг тодорхой хэвлэлийн хурлыг хийлээ.

Энэ нь юутай холбоотой вэ гэхээр Боловсролын сайд П.Наранбаяр гэж хүнтэй холбоотой асуудал байна.

Ерөнхий сайдад шаардлага хүргүүлэх ийм хэвлэлийн хурлыг хийлээ.

Энэ хүний хувьд нэгдүгээрт өнөөдөр Монгол Улсын ирээдүй болсон боловсролын салбарыг өнгөрсөн жилийн хугацаанд удирдлаа.

Өнгөрсөн 9 сард 1.2 тэрбум төгрөгийг нэр бүхий сургуулиуд руу шилжүүлж байгаад буцаагаад өөрийнхөө төрийн бус байгууллага руу төвлөрүүлсэн ийм баримт нь гарч ирлээ.

Сая ЭЕШ буюу ерөнхий шалгалтын дүнг зассан нөхцөл байдлыг бас холбогдох хүмүүс нь мэдээлж нотоллоо.

Гуравт, хаана байдаг нь мэдэгдэхгүй баахан Солонгосын судлаач гэдэг улсуудыг авчирч монгол зан заншил, монгол ёс суртахуун, монгол хүний өв уламжлал гэдэг зүйл рүү халдаж ЭЕШ-ын энэ материалыг бэлдүүлсэн байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор янз янзын асуултууд, янз янзын сөрөг үр дагаврууд гарлаа.

Үүнийгээ өөрөө тайлбарлахдаа жил болгон ерөнхий шалгалт дээр алдаа дутагдал гардаг юм гэж болдог зүйл мэтээр тайлбарлалаа.

Дээр нь сүүлийн үед дээд боловсролтой хүүхдүүдийн тоо ихдээд байгаа учраас бараг ЭЕШ-ын шалгалтад албаар унагах гэж бэлдсэн юм ч гэх шиг нэг иймэрхүү юм яриад сууж байдаг ийм Боловсролын сайд өнөөдөр байж болох уу, үгүй юу гэдэгт би эргэлзэж байна.

Тэгээд өнөөдөр хамтарсан засаг, эв нэгдэл гэдэг нэр нэрийн доор шударга бус байдлыг, энэ хууль зөрчсөн байдлыг хараад сууж байх боломж байхгүй гэдгийг би бас хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Тийм учраас Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Ерөнхий сайдаар томилогдохдоо хэлж байсан үгийг та эргэн санаж энэ авлигатай холбоотой, ашиг сонирхолтой холбоотой зөрчил гаргасан сайд нарыг тэр өдөрт нь чөлөөлнө гэдэг энэ хариуцлагыг тооцохыг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс танд шаардлагыг хүргүүлж байгаа.

Бусдаар манай бүтэц, бүрэлдэхүүн хумигдаад ороод ирлээ. Тодорхой түвшинд бүтээмжээ сайжруулах бодлогууд нь ороод ирлээ.

Хоёр дахь хэлэлцүүлгээс сая чиг үүргүүд нь бас эцэслэгдээд тодорхой боллоо.

Тэгэхээр одоо бид юу хэлэлцэх вэ. Одоо үүнийгээ хурдан батлаад Засгийн газрын үйл ажиллагаанд нь оруулах шаардлагатай байна. Дараагийн асуудал бид энэ төсвийн тодотгол орж ирэх юм байна. Гэх мэтчилэн иймэрхүү

зүйлүүдээ яаралтай хэлэлцээд явах нь зөв байх гэдэг ийм байр суурийг илэрхийлье. Асуулт байхгүй. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар гишүүн танилцуулна.

Хоёр.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Дараагийн асуудалд оръё.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Би Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохих тайлбарыг танилцуулъя.

23.1.Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ.

23.2. Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нэр дэвшигчийг дэмжсэн бол Байнгын хорооны даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно гэсэн хуулийг Та бүхэнд танилцууллаа.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулгыг Та бүхэнд танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Цэндийн Сандаг-Очирыг санал болгож байна.

Цэндийн Сандаг-Очир нь 1977 онд Төв аймгийн Баяндэлгэр суманд төрсөн.

Эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. 1995 онд нийслэлийн Багануур дүүргийн 66 дугаар дунд сургуулийг төгссөн.

2000-2004 онд Тэнгэр дээд сургуулийг философич, нийгмийн ухааны багш чиглэлээр суралцаж төгссөн. Философич, нийгмийн ухааны багш мэргэжилтэй.

2001 онд Удирдлагын академи, Төрийн удирдлагын менежер, Удирдлагын академийг төгссөн. Төрийн удирдлагын менежер.

2018 онд Удирдлагын академийг төрийн удирдлагын магистраар сурч төгссөн байна.

Ажлын туршлага 2000-2004 онд Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 4 дүгээр хорооны нийгмийн ажилтан, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн.

2005-2008 онд Багануур дүүргийн Монгол Ардын намын хорооны дэд дарга.

2008-2012 онд он, 2016-2020 онд Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргаар хоёр удаа 8 жил ажилласан.

2013 оноос одоог хүртэл Багануур дүүргийн Монгол Ардын намын хорооны даргаар сонгогдон ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 2 удаа, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 2 удаа сонгогдож байсан.

2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирын Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэрийг нь дэвшүүлж байна.

Байнгын хорооны даргад өөр нэр дэвшүүлэх саналтай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшсэн Цэндийн Сандаг-Очироос асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн оролцож, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

“Байнгын хорооны даргыг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн мөрдсүгэй гээд Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Ц.Сандаг-Очир гишүүндээ баяр хүргэе. /алга ташив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар гишүүн танилцуулъя.

Энэ чинь Их Хурал дээр сонсож байж байраа солих уу, үгүй юу? Одоо сольчих юм уу? Уг нь сонсох шүү дээ. Тийм.

**Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

О.Номинчимэг гишүүн, Л.Мөнхбаатар гишүүний саналыг нэмж оруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүнээс 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

15 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 73.3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүнээс 2025 оны 06 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

15 гишүүнээс 11 гишүүн санал хураалтад оролцож, 73.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

**Дөрөв.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн
2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Нэг асуудал байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүнээс 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хийнэ.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг нам харгалзахгүй, олон намын төлөөлөл, парламентад суудалтай бүх 5 намын төлөөлөл орсон 40 нэр бүхий гишүүн дэмжсэн байгаа. Дэмжиж өргөн барьсан.

Хуулийн танилцуулгад дурдагдсан зүйлүүдийг товч танилцуулъя.

Монгол үндэстний дэлхийн олон улсаас ондооших гол ялгарал, түүх, соёлын илэрхийлэл бол үндэсний их баяр наадам билээ.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлийг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр юм.

Монголчуудын үндэсний бахархлын бадрааж, нүүдлийн соёл иргэншлийг дэлхий дахинаа сурталчилдаг үндэсний их баяр наадам бол монгол түмний үндэсний ижилсэл, ондоошлын ухамсарт гүн нөлөөтэй чухал үнэт зүйл, арга хэмжээ юм.

Тиймээс Монгол улсын түүхийн бүхий л цаг хугацаанд монголчуудын үндэсний ухамсрыг сэргээх үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Үндэсний их баяр наадмыг баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тусгайлан зохицуулж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хууль 2003 оны 06 дугаар сарын 19-нд анх батлагдсанаас хойш тус хуульд нийт 8 удаа өөрчлөлт оржээ.

2022 оны 06 дугаар сарын 28-нд шинэчилсэн найруулга хэлбэрээр хуульд томоохон өөрчлөлт орсон.

Уг шинэчилсэн найруулгаар наадмын зохион байгуулалтын бүтэц, хариуцлагын тогтолцоо, уламжлалт спортын дүрэм журам гэх зэрэг наадмын зохион байгуулах эрх, үйл ажиллагааны зохицуулалтын шинж чанартай өөрчлөлтүүдийг хийжээ.

Харин үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийн бэлгэдэл болохын хувьд үзэл санаа, төрт ёсны, түүхэн уламжлалыг тодотгосон өөрчлөлт хараахан оруулаагүй байна.

Тиймээс 126 гишүүнтэй шинэ парламент энэхүү үзэл санааны өөрчлөлтийг оруулах нь чухал юм гэж үзэж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10-д Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ гэж заасан нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэнд ач холбогдол бүхий тэмдэглэлт ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх нь зүйтэй гэсэн санааг агуулжээ.

Хэдий уг хуульд зөвхөн хоёр түүхэн ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх тухай заасан боловч үе үеийн Ерөнхийлөгч нарын нээлт, хаалтын үг болон Баяр наадмын тухай албаны мэдээлэлд Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баярын талаар олонтоо дурдаж цохон тэмдэглэсэн байдаг.

Тиймээс Монгол Улсын түүхэнд ач холбогдол бүхий Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ой, Улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгах шаардлагатай гэж үзсэн.

Хуульд тусгайлан заагаагүй боловч дээрх түүхэн ач холбогдол бүхий ойн баяруудыг улсын баяр наадмыг тэмдэглэх үеийн албаны мэдээлэлд дурдаж ирсэн практик бий.

Тухайлах юм бол 2019 онд Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхэд албан ёсны эх сурвалжид Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108, Ардын хувьсгалын 98, Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойн баярын талаар цохон тэмдэглэж байжээ.

Харин 2024 онд Тулгар төр байгуулагдсаны түүхт 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардчилсан хувьсгалын 103 жилийн ойн баярын талаар онцолж байжээ.

Тиймээс Монгол Улсын төрт ёсны түүхэнд чухал ач холбогдол бүхий дээрх ойн баяруудыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгаснаар үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бүрэн илэрхийлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Иймээс энэхүү хуулийг дэмжиж өгөөч ээ гэж эрхэм гишүүд Та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Алга байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Үг хэлж дууслаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ. О.Номинчимэг гишүүнийг дэмжсэнээр авъя.

Ингээд Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа уншиж танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 24 минут үргэлжилж, 16 цаг 32 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД